

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАСГИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт(хүрээгүй бол тайлбар)	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.							
Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах							
1.1.1	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах.	-	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газраас Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан 2 дүрэм, 6 журам, 11 тогтоол, 9 тушаал, 12 заавар, зөвлөмж, 9 аргачлал, чиглэл, 28 тайлбар, мэдээ мэдээллийн хэрэгжилттэй танилцан ажилласан. Мөн 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шинээр нэвтрүүлсэн SICOS программыг нэвтрүүлэхтэй холбоотой батлагдаж ирсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлтэй тухай бүрт танилцан хариуцсан байцаагч, албан хаагчдад хүргүүлж, ажилдаа дагаж мөрдөн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2019-2023 онд шинээр тэтгэвэр тогтоосон 9817 иргэн, Үүнээс 6, 7 жилийн дундаж цалингаар тэтгэвэр тогтоогдсон 4975	90

					иргэн, дунд цалингүй 4842 тэтгэвэр авагч нарт тэтгэврээ өөрчлөн тогтоолгох тухай “Урилга”-г 1-24 дүгээр хорооны хэсгийн ахлагчтай хамтран биечлэн хүргүүлж ажилласнаар нийт 2179 тэтгэвэр авагч дундаж цалингаа өөрчлүүлэх хүсэлт өгч өөрчлөн тогтоолгосон. 2024 оноос эхлэн салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэнтэй холбоотойгоор нийт 722 иргэдийг шинэ системд хүсэлт үүсгэн шинэчилсэн хуулийн дагуу тэтгэврийг 5 жилийн цалингийн дундажаар бодож тэтгэврийг хуулийн хугацаанд тооцож шийдвэрлэсэн. Мөн тэтгэврээ өөрчлүүлэх хүсэлтээ өгсөн 960 тэтгэвэр авагчдын хүсэлтийг SICOS системт оруулан өөрчлөн тогтоосон. 2024 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нийт тэтгэвэр авагчдын тэтгэврийг 100000 (нэг зуун мянган) төгрөгөөр нэмэгдүүлэхээр шийдвэрлэсний дагуу 24898 тэтгэвэр авагчдын тэтгэврийн өөрчлөлтөнд хяналт тавьж, өөрчлөн тогтоосон. Эхний хагас жилийн байдлаар SICOS системд ХЧТА-ны болон Жирэмсэн, амаржсаны, оршуулга, ажилгүйдлийн, тэтгэмжийн нийт 7387 хүсэлт ирсэнээс 5863 даатгуулагчийн хүсэлтийг хууль журмын дагуу шийдвэрлэгдэж, 1524 хүсэлт хяналтын шатанд шалгагдаж байна.	
--	--	--	--	--	--	--

Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах

2.1.9	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах.	-	Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад төгрөгийн тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан.	а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу төгрөгийг хуульд заасан хугацаанд зарцуулсан байна.	Арилжаа ! банкнуудтай байгуулсан гэрээний дагуу сар бүрийн 1-нд олгох тэтгэврийн файлыг өмнөх сарын ажлын сүүлийн өдрийн 10 цагт харилцагч банкнуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн цахимаар хүргүүлэн тэтгэврийг сар бүрийн 01-ны өдөр хугацаанд нь олгон ажилласан. Программын өөрчлөлттэй холбоотой шинээр тогтоогдсон, шилжин ирсэн, SICOS системд хөрвөж ороогүй, хугацааны сунгалт хийгдсэн болон ХЧА-ын хувь өөрчлөгдсөн тэтгэвэр авагчдын тэтгэврийг нэмэлтээр жагсаалт бэлтгэн сард 4-5 удаа харилцагч банкнуудад цахимаар илгээн тэтгэврийг нэмэлтээр олгож хэвшсэн. Нас барсан тэтгэвэр авагчдын дараа сарын тэтгэвэр олголтыг тэтгэврийн файл бэлдэхээс өмнө ирсэн тохиолдолд ар гэрийнхний өгсөн өргөдлийг хүлээн авч 24 цагийн дотор гэр бүлийн гишүүний арилжааны банкны дансанд шилжүүлж байна. Ажил олгогч даатгуулагчдын ХЧТА болон ЖА-ын тэтгэмжийн олголтыг тэтгэмжийн улсын байцаагчаар хянуулж баталгаажуулсны дараа гүйлгээний жагсаалтаар 7 хоногт 2-3 удаа гүйлгээ хийж олгож байна. Ажилгүйдлийн тэтгэмжийг сар бүрийн 20-25-ны өдрийн хооронд жагсаалтаар, мөн тухайн сарын 25-наас хойш тэтгэмжийн баримт бичиг бүрдүүлэн өгсөн даатгуулагчдын тэтгэмжийг тогтоон хянуулсны дараа тухай бүрд нь Санхүүд жагсаалтаар олголтыг хийгдэж өгч байна.	100
Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах							

4.1.1.	Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх.	-	Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	2023 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын газруудад НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 83,5%-тай хэрэгжсэн байна	Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.	Шинээр SICIS системийг нэвтрүүлсэнтэй холбоотой Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 01/1107 албан тоотын дагуу 2024 оны 01-05 дугаар сарын тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголт өөрчлөлт, шилжилт хөдөлгөөн зэрэг мэдээллийн олголтыг цахим болон жагсаалтаар бэлтгэхэд алдаа гарах, сангийн эрсдэл үүсэхээс сэргийлэн тэтгэвэр, тэтгэмжийн олголтонд хяналт шалгалт хийх төлөвлөгөө гарган Газрын даргаар батлуулан ажиллаж байна. Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь тухай бүр хүргүүлж байна.	95
4.1.2.	ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах.	-	Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна.	Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2023 онд 89,1 %-тай хэрэгжсэн байна.	Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.	Абле программаар НДЕГ болон дотоод байгууллагаас ирсэн нийт 480 албан бичгээс хариутай албан бичиг 76 үүнээс шийдвэрлэсэн нь 437 хяналтын шатанд 43, хариугүй албан бичиг 337 үүнээс шийдвэрлэсэн нь 254 байна. Абле программаар 457 албан бичиг, үүнээс 455 бичиг шийдвэрлэж 2 бичиг хянагдаж байгаа тухай бүр ирсэн бичгийн хүсэлтийг холбогдох байгууллагууд руу хүргүүлэв. Edoc программаар нийт 480 албан бичгийн хариуг хугацаанд шийдвэрлэсэн ба 43 бичиг хяналтын шатанд байна. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой тоон гарын үсэг ашиглан 345 албан бичгийг хариуцах байгууллага руу шилжүүлсэн байна.	100

						Иргэд болон аж ахуй нэгж байгууллагаас нийт 261 өргөдөл хүлээн авснаас Абле программаар 241, Edoc программаар 232 өргөдлийг холбогдох хавсралт нотлох баримтуудыг шалган бүртгэл хөтлөн газрын даргаар цохуулж холбогдох ажилтанд шилжүүлж, хуулийн хугацаанд нь шийдвэрлүүлэн, сар бүр газрын даргад танилцуулан, НДЕГ болон ННДГ-т тайлан хүргүүлж байна. Шийдвэрлэх явцад хугацаа хэтэрсэн болон шийдвэрлэх процесст саад учирсан тохиолдолд газрын даргад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч, ажиллаж байна. Газрын даргын хурлаар өгсөн чиглэл, үүрэг даалгаврыг танилцуулж албан хаагчдын албан хэрэг хөтлөлт, явцын тэмдэглэл хөтлөх ажил олгогчоос ирүүлсэн албан хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна.	
4.1.3.	Нийгмийн даатгалын байгууллагын салбарын хэмжээнд архивын үйлчилгээг сайжруулах, ажил олгогч, иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх.	-	Нийгмийн даатгалын газар дотооддоо болон газар хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг зохион байгуулна.	Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлсэн.	Архивын лавлагааг цахимаар солилцох боломжийг бүрдүүлсэн байна.	Тайлант хугацаанд иргэд даатгуулагчдад ажилласан жилийн шимтгэл төлөлтийн лавлагаа олгох, бусад аймаг дүүрэг, цагдаагийн газраас абле болон эдок программаар ирсэн хүсэлтийн дагуу архивын баримтыг шүүн лавлагаа, тодорхойлолт гарган хүргүүлж, газрын дотоод ажлын хүрээнд шаардагдсан баримт бичгүүдийг архиваас ажилтан, байцаагч нарт бүртгэл хөтлөн түр ашиглуулах, хяналт тавьж, буцаад хүлээж авах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Эхний хагас жилийн байдлаар 1992-1994 оны байгууллагын шимтгэл төлөлтийн тухай лавлагаа 130, 1995-2005 оны хувь хүний шимтгэл төлөлтийн лавлагаа 610, 2006-2023 оны QR лавлагаа 184, 1990-2000 нөхөн даатгалын	95

						тодорхойлогч 190, шимтгэл төлдөггүй тухай лавлагаа 110 тус тус архивын баримтаас шүүн иргэд, даатгуулагч нарт чирэгдэлгүй, түргэн шуурхай гаргаж олгосон. Цахимаар Абле программ болон дотоод сүлжээгээр аймаг, дүүргүүдээс ирсэн хүсэлтүүдийн дагуу нийт 185 иргэний шимтгэл төлөлтийн лавлагааг гарган хүргүүлж, архивын лавлагаа авах хүсэлтийг аймаг, дүүргүүдэд 88 хүсэлтийг цахимаар илгээж, 185 хүсэлтийн хариуг иргэд, даатгуулагч нарт хугацаанд нь гарган өгч ажилласан байна.	
						Edoc программаар чингэлтэй дүүргийн цагдаагийн газраас ирсэн 18 шимтгэл төлөлтийг лавлагаа албан бичгийн хариуг боловсруулж хуулийн хугацаанд нь хүргэж ажилласан. Мөн газрын дотоод үйл ажиллагаанд шаардагдсан 290 баримтыг дотоод хэрэгцээнд түр ашиглуулан, бүрэн хүлээн авч тухай бүр тэмдэглэл хөтөлж ажилласан.	
4.1.4.	Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах.	-	Төрийн албаны тухай хууль тогтоомж, журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргаж байна.	Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангах.	Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргаж НДЕГ-т Тамгын газарт улирал бүр тайлагнасан байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны бүтэц, орон тоо батлах тухай А/22 дугаар тушаалаар батлагдсан орон тоог бууруулахгүй ажилтнуудыг томилон ажлуулах журмыг баримтлан ажиллаж байна. Нийгмийн даатгалын Ерөнхий газарт хүний нөөцийн тайланг үнэн зөв хуулийн хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Түүнчлэн хүний нөөцтэй холбоотой НДЕГ болон бусад төрийн эрх бүхий байгууллагаас ирүүлсэн судалгаа мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн гүйцэт, үнэн зөв зааврын дагуу боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчаар хянуулж, албан бичгээр	95

						хариуг өгч, үргүүлж ажилласан. Мөн Төрийн захирааны, үйлчилгээний албан хаагчдын ажлаас чөлөөлөгдсөн, шинээр ажилд томилогдсон, сахилгын шийтгэл ногдуулсан, өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, төрийн өөр байгууллага, ажлын зайлшгүй шаардлагаар өөрийн хүсэлтээр нэгж дотор шилжүүлэн ажиллуулсан нийт 25 албан хаагчийн тушаалыг Төрийн албаны тухай хууль, хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчаар хянуулж, баталгаажуулсан.	
4.1.5.	Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх	-	Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.	Газрын ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байх.	Газрын дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.	Иргэд даатгуулагчдыг сэтгэл ханамжийн үнэлгээ өгөх боломжийг бүрдүүлэх зорилгоор газрын нэг цэгийн үйлчилгээний байцаагч нарын товч мэдээлэл бүхий QR, сэтгэл ханамжийн судалгааны QR кодыг байцаагч тус бүрийн өмнө байршуулан иргэд даатгуулагчдад сурталчлан, мэдээлэл өгч ажиллаж байна. Мөн сэтгэл ханамжийн судалгааг газрын албан ёсны веб хуудсаар шууд дамжуулан авч судалгааны нэгтгэл дээр анализ хийж ажиллаж байна. Үйлчлүүлэгч даатгуулагч иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авч үйлчилгээний стандарт, байцаагч ажилтнуудын харьцангуй хандлагыг сайжруулах цаашид хэвшүүлэх, мэдээлэлд шаардлагатай хүчин зүйлсийг илрүүлэхэд судалгааг тогтмол авч хэвших нь судалгааны дүгнэлтүүдээр харагдаж байгаа. Мөн уг төхөөрөмжийг ашиглан нийгмийн даатгалын шимтгэл төлөх дансны дугаарыг харах, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг хэвлэж авах бүрэн боломжтой.	95

						Дотоод ажлын төлөвлөгөөний дагуу албан хаагчид номын булангаа баяжуулан дуртай номоо солилцон унших боломжийг бүрдүүлэн газрын 204 тоот өрөөнд “Номын булан” шинээр санаачлан тохижууллаа. Номын баяжилтыг албан хаагчид өөрсдөө хийж номуудыг кодлон номын сангийн журмаар солилцон уншиж байгаа. Газрын байрны төв хаалганы хажууд зам дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэний машин байршуулах тэмдэг тэмдэглэгээг зурж байршуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэд өндөр насны тэтгэвэр тогтоолгох, нийгмийн даатгалын үйлчилгээг авах иргэд даатгуулагчдад үйлчилгээг түргэн шуурхай хүргэн зогсоолын хүртээмжээс болж үйлчилгээ авахад саад учир болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж зогсоолын тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу зурж байршуулан ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй дугаар авахгүй шууд үйлчилгээг үзүүлэх зорилгоор дугаар харгалзахгүй үйлчилгээ авах таних тэмдэг байрлуулж ажилласан.	
4.1.6.	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах.	-	Газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан байна.	Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлнэ.	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, үр дүнг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын	Тус газар нь албан хаагчдын “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг дагуу төрийн албаны тасралтгүй байдлыг хангах зорилгоор тус газрын ажилтан албан хаагчдын хүний нөөцийн төлөвлөлтөд анхаарч, ажилтнуудын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хүний нөөцийн оновчтой зөв байршуулах, чадавхыг дээшлүүлэх, зорилгоор тухайн албан хаагчтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр холбогдох хууль тогтоомжийн дагуу тасаг дотор шилжүүлэн ажилдуулах	95

					Газарт тайлагнасан байна.	зохион байгуулалтыг хийж, ажиллаж байна.	
4.1.7				Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг байгуулах.	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.	Авлигын эсрэг хуулийн 18.4.10-т заасны дагуу хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод тусгасан чиг үүргийн хүрээнд газрын нийт албан хаагчдаас нууцын баталгааг гаргуулан авч, байгууллага болон хувь хүний нууцыг бусдад задруулахгүй байх үүргийг хэрэгжүүлэх талаар албан хаагчдад тогтмол зөвлөмж анхааруулга өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Тус газар нь нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудыг ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, ёс зүйг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, идэвхжүүлэлтийн арга хэмжээг зохион байгуулж, мэдлэг олгох цахим сургалтуудыг зохион байгуулсан. Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зөв мэдүүлэх, төрийн албаны ёс зүйг дээдлэн ажиллах талаар нийт албан хаагчдад тогтмол мэдээлэл зөвлөгөө өгч ажилласны үр дүнд газрын 19 албан хаагч хуулийн хугацаанд ХАСХОМ бөглөсөн бөгөөд https://meduuleg.iaac.mn/ сайтад ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд бүртгэн оруулж тухайн албан хаагчийн мэдээллийг нийтэд ил нээлттэй болгон хяналт тавьж ажилласан. Мөн шинээр болон төрийн захиргааны өөр байгууллагаас шилжин ирсэн төрийн захиргааны албан тушаалд томилогдсон 23 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж, төрийн захиргааны албан тушаалд томилогдох албан хаагчийн	100
	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх	-	Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан байна.	зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах.			

						урьдчилсан мэдүүлгийн албан тоотыг боловсруулж, януулж, хүргүүлсэн. Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зөв мэдүүлэх, төрийн албаны ёс зүйг дээдлэн ажиллах талаар нийт албан хаагчдад тогтмол мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаж байна. Мөн Засгийн газраас хэрэгжүүлж буй АТГ авлигын эсрэг “НЭГДБЕ” соён гэгээрүүлэх аяныг орон даяар эхлүүлсэнтэй холбоотойгоор авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид эрүүл нийгмийг бүтээхийн төлөө хамтдаа нэгдье урианд дор нэгдэж газрын албан ёсны цахим хуудсаар дамжуулан мэдээлэл сурталчилгааг хүргэж ажиллаж байна.	
4.1.8	Нийгмийн даатгалын газрын ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах	-	НДЕГ-ын 2016.12.07-ны өдрийн “Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)-ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам” батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн “Нийгмийн даатгалын газар (тасаг)-ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт” батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг	-	Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулж, ажлын байр, үйлчилгээний орчны стандарт хэрэгжилтийг ханган ажилласан байна.	НДЕГ-ын 2016.12.07-ны өдрийн “Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)-ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам” батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн “Нийгмийн даатгалын газар (тасаг)-ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт” батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжүүлэн ажилласан байна. Тус газар нь ажил үйлчилгээнд гарч байгаа алдаа зөрчил, иргэд даатгуулагчдаас ирж байгаа өргөдөл гомдлыг чирэгдэлгүй, шуурхай шийдвэрлэх, төрийн үйлчилгээний төгөлдөршлийг бий болгох зорилгоор Чанарын менежментийн тогтоолцоо ISO 9001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, төлөвлөгөө боловсруулж, ажлын байрны үйлчилгээний орчны стандартыг сайжруулан ханган ажиллаж байна.	95

			мөрдөж ажиллаж байна			Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлж ажилласнаар байгууллагын ажлын байрны үйлчилгээний стандартыг сайжруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд даатгуулагчдад чиглэсэн зогсоол, дугааргүй үйлчлэх, цахим үйлчилгээ зэргийг хэвшүүлж, албан хаагчдын хувцаслалт, үйлчилгээний харилцаа хандлагыг мөрдлөг болгон ажиллаж, даатгуулагчдад зориулан мэдээллийн самбарыг шинэчлэн байршуулж ажиллаж байна.	
						Монголын бүтээмжийн төвтэй хамтран 2024 оны 3 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоонд дотоод аудит хийх, дотоод аудитор бэлтгэх сургалтад тус тасгаас тасгийн дарга М.Отгонцэцэг, байцаагч Б.Ануужин нар хамрагдаж үйлчилгээний стандартад хяналт тавьж ажиллаж байна.	

Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар газар, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах

4.2.1	Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах;	-	Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамруулсан хүний тоо	Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 41 удаагийн сургалтад 46 албан хаагчийг хамруулсан.	Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх танхимын болон цахим сургалт зохион байгуулна. -Шинэ ажилтныг ажлын байран дээр дадлагажуулах	Тус газар нь нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудыг ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, ёс зүйг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, идэвхжүүлэлтийн арга хэмжээг зохион байгуулж, сургалтын файл хичээлүүдийг албан хаагчдад тараан өгч, бие даан судлуулсан. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүй комиссын хурлаар "Архивын тухай" Байгууллагын Архивын ажиллагааны нийтлэг журмын дагуу "Байгууллагын Архивын гэрчилгээ" авах танилцуулга бэлдэж хурлаар орж "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын" 2.8, 2.9, 2.10, 6.7 дах	100
-------	--	---	---	--	---	--	-----

					сургалт байгуулж, чадвар мэргэжилтэн бэлтгэнэ. зохион хөрвөх бүхий	заалтуудыг тус хэрэгжүүлэн ажиллаж, Архивын байр, өрөөний талаар сургалтыг нийт албан хаагчдад 2 удаа практик сургалтыг зохион байгуулж ажиллалаа. 2024 оны 3 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулагдсан "ISO 9001:2015 ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ДОТООД АУДИТОР БЭЛТГЭХ" сургалтад М.Отгонцэцэг, Ц.Жаргалсайхан, Б.Ануужин А.Сэлэнгэ нар хамрагдаж батламж авч дотоод аудит хийж ажиллаж байна. 2024 оны 03 дугаар сарын 20-ний өдөр "Захирамжлахыг баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, Абле edoc системд хөрвүүлэх нь" сэдэвт сургалтад цахимаар архивын ажилтан Х.Даваажаргал, Б.Болорчимэг нар зохион байгуулж газрын албан хаагчдад сургалтыг танилцуулж архив албан хэргийн хөтлөлт стандартын дагуу архивыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг дагуу бэлтгэх заавал зөвлөмж өгч сургалтыг зохион байгуулж ажилласан. Сургалтын төлөвлөгөөний дагуу нийгмийн даатгалын хууль тогтоомж шинэчилсэн найруулгын талаар сургалтыг нийт байцаагч ажилтан албан хаагчдад Үйлчилгээний тасгийн дарга З.Мөнхнаран сургалтыг төлөвлөгөөний дагуу удирдан зохион байгуулж ажилласан. Сургалтаар хуулийн хэрэгжилт болон тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой нийтлэг гаргадаг алдаа дутагдлыг арилгуулах цаашид анхаарах асуулаад сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Монголын бүтээмжийн төв нь 2024 оны 03 сарын 22 өдөр бүтээмжийн зөвлөлийн гишүүдэд зориулан "Чанарын
--	--	--	--	--	--	--

					дугуйлан гэж юу вэ, ЧД-г хэрхэн хэрэгжүүлэх, үүний ач холбогдол, ЧД-аар дамжуулан байгууллагын бүтээмжийг хэрхэн нэмэгдүүлэх талаар ойлголт өгөх, чиглүүлэг” сургалтыг амжилттай зохион байгууллаа. Сургалтаар "ЧД-ийн гишүүдийн зохион байгуулалтыг танилцуулах, чанарын дугуйлангийн ойлголт ба зарчмын тухай, байгууллагад ЧД-г хэрэгжүүлэх менежмент арга, чанарын хяналтын үндсэн 7 арга, мөн багын ажиллагаа зохион байгуулж заавар зөвлөгөө өглөө. Нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомж шинэчилсэн найруулгын талаар сургалтыг нийт байцаагч ажилтан албан хаагчдад 7 хоног бүр тогтмол зохион байгуулах, тэдгээрт хяналт тавьж ажиллах талаар газрын даргаар батлуулсан хуваарийн дагуу тасаг бүр нийт 8 удаагийн сургалтыг зохион байгуулж ажилласан. Сургалтаар хуулийн хэрэгжилт болон тэтгэвэр тэтгэмж, хамралт, сайн дурын даатгал, цахим системтэй холбоотой нийтлэг гаргадаг алдаа дутагдлыг арилгуулах цаашид анхаарах асуулаад сургалтуудыг зохион байгуулж ажилласан.Тод санхүү сургалтын төв санхүү бүртгэлийн тасаг хамтран “Хувь хүний үнэ цэнэ өөрийгөө үнэлэх ажлын ачаалал даах чадвар”-ын сургалтыг 2024.03.26 өдөр санхүү бүртгэлийн тасгаас зохион байгуулж ажилласан. Жендерийн үндэсний хорооноос Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол царгийн өдрийг тохиолдуулан “Харилцан хүндэтгэе” нэг сарын аяныг зохион байгуулж байгаатай холбогдуулан тус газрын хамт олон	
--	--	--	--	--	---	--

					нэгдэн даах ажлуудыг хийж хэрэгжүүлээ. Тус арга хэмжээний хүрээнд газрын албан ёсны цахим хуудас (facebook)-ээр дамжуулан иргэд даатгуулагчдад уриалга хүргэж нийт 236 даатгуулагч иргэнд хүрч ажилласан. Жендерийн тухай ойлголт сэдвийн хүрээнд сургалтыг газрын албан хаагчдад зохион байгуулж ажиллалаа. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ. Монгол улсын засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолын хүрээнд дүүргийн засаг дарга бөгөөд онцгой комиссын даргын баталсан захирамжийн дагуу газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг дүүргийн онцгой байдлын газартай хамтран зохион байгуулж ажиллалаа. Архив бичиг хэрэг дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Намжилсүрэн, архивын ажилтан Б.Болорчимэг, Д.Даваажаргал архив бичиг хэргийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг дагуу баримыг үдэж хадгаламжийн нэгж үүсгэх, алдаа дутагдлыг арилгах сургалтыг зохион байгуулж ажилласан. Хүүхэд хүмүүжлийн эерэг арга, хүүхэдтэй хэрхэн хариуцах вэ сургалтыг Чингэлтэй дүүргийн хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нармандах удирдан явуулж нийт албан хаагчид хамрагдлаа. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага солилцох албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор БНХАУ-ын Хөх хотод 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 04-дүгээр сарын 21-ний хооронд
--	--	--	--	--	--

					тус газрын орлого шимтгэлийн байцаагч С.Доржпагам хамрагдлаа. "Хүний хөгжил-Нийгмийн баталгаа -2024" арга хэмжээ батлах тухай 32 дугаар тогтоолын хүрээнд ажилтан албан хаагчдад мэдлэг мэдээлэл олгох, амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор "Эрүүл дадлыг бүтээцгээ"сэдэвт сургалтыг сургагч багш М.Баярцэцэг удирдан явуулж эрүүл зөв хооллолтын талаар сургалт мэдээллийг нийт албан хаагчдад хүргэж ажилласан. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх захиргааны шийдлүүдийн талаар ОУХБ-ОУСС-ын сургалтад орлого шимтгэлийн тасгийн дарга М.Отгонцэцэг оролцлоо. Цахим шилжилтэд нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн төрийн албан хаагчдын оролцоо, хамтын ажиллагааг нэгтгэх, тулгарч буй асуудал, санал шүүмжийг сонсох "Шилэн төр, төрийн хурдан үйлчилгээ" зөвлөгөөнд тус газрын 30 албан хаагч хамрагдаж оролцлоо. Тус зөвлөгөөнд Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн төрийн албан хаагчид, цагдаагийн болон онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүн оролцлоо. Иргэд даатгуулагч, ажил олгогчийн захирал нягтлан бодогчдод нийгмийн даатгалын ажил үйлчилгээг хүртээмжтэй шуурхай хүргэх, нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт, түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг танилцуулах, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх сургалтыг тогтмол зохион байгуулж, шинээр ажил олгогчоор бүртгүүлэх заавар, гарын авлага QR код, сайн дурын даатгалд хамрагдах иргэдэд зориулсан	
--	--	--	--	--	---	--

					мэдээлэл, газрын авлага QR кодыг бэлтгэн: 1. Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газрын нэг цэгийн үйлчилгээний танхимд 2. Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн газрын нэг цэгийн үйлчилгээний танхим хуулийн этгээдийн бүртгэл хэсэгт, мэдээллийн самбарт 3. Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн мэдээллийн самбарт 4. Чингэлтэй Дүүргийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний хэлтсийн нэг цэгийн үйлчилгээний танхим, мэдээллийн самбарт тус тус байршууллаа. Хувиар хөдөлмөр эрхлэгч иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сайн дурын даатгал, тэтгэвэр тэтгэмжийн даатгал, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ, бусад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, хамрагдалтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээ, ач холбогдлын талаар мэдээлэх, таниулах зорилгоор Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг зах худалдааны төвүүдтэй хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлэн “Нээлттэй хаалганы өдөрлөг” явуулын үйлчилгээг иргэд даатгуулагчдад хүргэн ажиллаж байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар: Чингэлтэй Дүүргийн Засаг даргын тамгын газртай хамтран дүүргийн нийт иргэд даатгуулагчдад сайн дурын даатгал, тэтгэврийн даатгалын талаар зөвлөгөө мэдээллийг хүргэх, сайн дурын	
--	--	--	--	--	--	--

						даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд видео танилцуулгыг бэлтгэн 1-24 дүгээр хороодын иргэний танхимаар дамжуулан хүргэж байна.	
4.2.2	Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах;	-	Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 52 удаагийн сургалтад 19653 иргэд, даатгуулагчийг хамруулсан.	Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилж, хамралт нэмэгдсэн байна.	Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын ажил үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай хүргэх, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн хүсэлтийг цахимаар хүлээж авах, тогтоох, олгох ажлыг сурталчлан таниулах зорилгоор тэтгэмжийн хүсэлтийг цахимаар илгээх QR гарын авлага брошюр бэлтгэн, 130 гаруй иргэд даатгуулагчид, ажил олгогч нягтлан бодогч нарт тараан сурталчилж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.	
						Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, цахим үйлчилгээний талаар иргэд даатгуулагчдад мэдээлэл хүргэх, сурталчлан таниулах зорилгоор цахим хуудсаар дамжуулан нийт 38 мэдээ мэдээллийг пост хэлбэрээр хүргэж нийт 11956 иргэд даатгуулагчдад түгээн хүргэсэн. Нэмэлт өөрчлөлт мэдээллийг Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газрын албан ёсны цахим хуудсаар тогтмол түгээн сурталчлах ажлуудыг хийж хэвшсэн. ААНБ-ын шинэ системийн эрх үүсгэх, ажил олгогчдын мэдээлэл өөрчлөх, бүртгэх, тайлан илгээх ажил мэргэжлийн ангилалтын тухай сургалтыг нийт 104 ААНБ-ын нягтлан бодогч, хүний нөөц нарт нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаар мэдээлэл хүргэж ажилласан. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчид, МСҮТ, их дээд сургуулийн оюутнуудыг хамруулсан, нийгмийн даатгалын ач	90

					холбогдлыг сурталчлан таниулах зорилготой "даатгалтай ирээдүй" сэдэвт сургалтыг 3 дугаар сарын 26-29-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус сургалтаар ерөнхий боловсролын 5, 50 сургуулийн 42 сурагч, 2 их дээд сургуулийн нийт 41 оюутан сурагч хамрагдлаа. Сургалтын явцад 9 оюутан, сурагчид гар утасны аппликэйшн суулгаж, нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаар товч мэдээлэл хүргэсэн. Тус газар нь 2024 оны 03 дугаар сарын 15-ний өдөр төсөвт байгууллагын нягтлан бодогч нарт Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд, журам заавар, цахим үйлчилгээний талаар, шимтгэл төлөлтийн тайланд гарч байгаа зөрчлүүдийг арилгах, хуулийн хугацаанд үнэн зөв тайлагнахад мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгч үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга замыг хэлэлцэж, цаашид зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх талаар сургалт уулзалтыг зохион байгуулж харилцан санал солилцлоо. Сургалтаар хуулийн хэрэгжилт болон аж ахуйн нэгж байгууллагуудын нийтлэг гаргадаг алдаа дутагдлыг арилгуулах цаашид анхаарах асуулаад сургалтыг зохион байгуулж ажилласан. Татварын албаны санхүү бүртгэлийн ажилтнуудад зориулсан Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилт түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүдийн талаар хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл өгөх зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр татварын	
--	--	--	--	--	--	--

					ерөнхий газрын 38 албан хаагчдад сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Эрүүл мэндийн ерөнхий газрын санхүү бүртгэлийн ажилтнуудад зориулсан Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилт түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүдийн талаар хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл өгөх зорилгоор 2024 оны 05 дүгээр сарын 20-ны өдөр сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Эрүүл мэндийн ерөнхий газрын санхүү бүртгэлийн газрын нийт 64 албан хаагчдад хамрагдаж оролцлоо. Хууль сурталчлах ажлын хүрээнд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газраас дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран Улсын бүртгэлийн нэгдсэн системээс санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон 54 иргэдэд Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу шүүх хуралдаанд оролцохоор сонгогдсон иргэдийн төлөөлөлд сургалт зохион байгуулагдаж тус газрын хүний нөөцийн мэргэжилтэн мэдээ мэдээлэл өгч ороцлоо. Дүүргийн нутаг дэвсгэрт шашны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллуудын уулзалт зөвлөгөөнд хяналт шалгалтын тагийн байцаагч Ц.Жаргалсайхан нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн талаар сургалтыг нийт 59 иргэн даатгуулагчдад орж хамралтыг нэмэгдүүлэн ажиллалаа. Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-ын орон нутаг болон дүүрэг хариуцсан нягтлан бодогч нарт зориулсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга, кодын өөрчлөлт, залруулга	
--	--	--	--	--	--	--

					болон хамралтын талаар сурталтыг 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж нийт 110 нягтлан бодогч нар хамрагдлаа. Тус газар нь “Шуурхай чанартай төрийн үйлчилгээ аян”-ы хүрээнд Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ажил үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээллийг хүргэх зорилгоор Чингэлтэй дүүргийн 1-24 дүгээр хорооны хөгжлийн бэрхшээлтэй болон хэвтрийн биечлэн зөвлөгөө мэдээлэл авах боломжгүй 2400 иргэд даатгуулагчдад утсаар мэдээлэл өгч ажилласан. Зөвлөгөөнд 5 тасгийн бүх байцаагч ажилтнууд оролцож мэдээлэл өгсөн бөгөөд 2024 оны 05-р сарын 24 өдөр тайлан мэдээгээ хүргүүлэн ажиллалаа. Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ажил үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээллийг хүргэх зорилгоор Улсын их дэлгүүрийн урд байрлах талбайд асар байршуулан 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж нийт 120 иргэд даатгуулагчдад зөвлөгөө мэдээллийг хүргэж ажиллалаа. Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жилийн хүрээнд тус газар нь 2024 оны 06 дугаар сарын 06,07-ны өдрүүдэд “ИРГЭНД ҮЙЛЧЛЭХ-НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ”-ийг зохион байгуулж Нийгмийн даатгалын ажил үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай хүргэх зорилгоор “Нарантуул 2, Хүчит шонхор, Бөмбөгөр худалдаа үйлчилгээний төвүүдэд” нийт 520 иргэд даатгуулагчдад зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан. Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хорооны Засаг даргын ажлын алба, Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Чингэлтэй дүүргийн Нийгмийн	
--	--	--	--	--	--	--

						даатгалын гэр хамтран 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдөр “НЭЭЛТТЭЙ ХААЛГА”-ны өдөрлөгийг зохион байгуулсан. Тус өдөрлөгт “Тэтгэвэр, тэтгэмж, Сайн дурын даатгал, Нийгмийн даатгалын цахим үйлчилгээ”-ний талаар нийт 56 иргэд даатгуулагчдад зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.	
4.2.3	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын		Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа хийсэн 55 тоо, мэдээллийн төрөл 18863	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай хүргэсэн байна. ХНХЯ болон НДЕГ-аас бэлтгэсэн мэдээллийг бүх албан хаагчдаар цааш түгээлгэж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна.	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай хүргэсэн байна. ХНХЯ болон НДЕГ-аас бэлтгэсэн мэдээллийг бүх албан хаагчдаар цааш түгээлгэж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээ ашиглан Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах талаар Иргэд даатгуулагч, ажил олгогч нарт нийгмийн даатгалын ажил үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийг цахимаар түргэн шуурхай хүргэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор газрын албан ёсны Facebook цахим хаягаар дамжуулан иргэд даатгуулагчдад тогтмол мэдээ мэдээлэл хүргэж, батлагдсан хуваарийн дагуу сар бүр шууд Live хийж, цахимаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.	90
	үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах;	-	үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг сурталчлах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл, Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-д байршуулсан мэдээллийн тоо, хандалтын тоо. Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео шторк, контент, цахим хичээл, постерын тоо. Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид,			2024 оны II улирлын байдлаар нийт 9 удаа шууд Live хийж, 16560 гаруй иргэд даатгуулагчид үзсэн хандалттай байна. Иргэд даатгуулагч, ажил олгогч нарт нийгмийн даатгалын ажил үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийг цахимаар түргэн	

			зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн сурталчилгааны тоо, төрөл зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл		шуурхай хүргэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор газрын албан ёсны Facebook цахим хаягаар дамжуулан иргэд даатгуулагчдад тогтмол мэдээ мэдээлэл хүргэж, батлагдсан хуваарийн дагуу сар бүр шууд Live хийж, цахимаар зөвлөгөө мэдээлэлийг тогтмол өгч ажиллаж байна. Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын ажил үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай хүргэх, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн хүсэлтийг цахимаар хүлээж авах, тогтоох, олгох ажлыг сурталчлан таниулах зорилгоор тус газар нь тэтгэмжийн хүсэлтийг цахимаар илгээх QR код бүхий 2 төрлийн заавар хийж, гарын авлага брошюр бэлтгэн, иргэд даатгуулагчид, ажил олгогч нягтлан бодогч нарт тараан сурталчилж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна. Иргэд даатгуулагчдыг сэтгэл ханамжийн үнэлгээ өгөх боломжийг бүрдүүлэх зорилгоор газрын нэг цэгийн үйлчилгээний байцаагч нарын товч мэдээлэл бүхий QR, сэтгэл ханамжийн судалгааны QR кодыг байцаагч тус бүрийн өмнө байршуулан иргэд даатгуулагчдад сурталчлан, мэдээлэл өгч ажиллаж байна. Мөн сэтгэл ханамжийн судалгааг газрын албан ёсны веб хуудсаар шууд дамжуулан авч судалгааны нэгтгэл дээр анализ хийж ажиллаж байна. Сэтгэл ханамжийн судалгааг хийснээр тус газрын үйл ажиллагаа үйлчилгээ, албан хаагчдын ажиллах нөхцөл боломж, шинээр хийж хэрэгжүүлэх ажилд шинэлэг санааг хүлээн авч хэрэгжүүлэхэд түлхэц болох үүднээс 2021 оноос хойш авч хэвшин ажиллаж байна.Мөн уг төхөөрөмжийг ашиглан
--	--	--	---	--	---

						нийгмийн даатгалын шимтгэл төлөх дансны дугаарыг харах, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг хэвлэж авах бүрэн боломжтой. Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг сурталчлан таниулах, хүртээмжтэй хүргэх зорилгоор 1-24 дүгээр хорооны байранд мэдээллийн самбарыг байршуулан шинэ хуулийн хэрэгжилт, өөрчлөлтүүдийн талаар иргэд даатгуулагчдад тогтмол хүргэж мэдээллийн шинэчлэлтийг хийж ажилласан.	
Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх							
4.3.1	Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн биелэлтийг ханган ажиллах	-	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад жилд 4-өөс доошгүй удаа хяналт хийсэн байна. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд хагас жил тутам тулгалт хийсэн байна.	Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭММТЗ-д хүргүүлсэн байна.	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад хяналт хийж холбогдох арга хэмжээ авсан байна. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд жилд 2 –оос доошгүй удаа тулгалт хийж зөрчил дутагдлыг тухай бүр арилгах арга хэмжээ авч ажилласан байна.	Эрүүл мэндийн магадлах зөвлөл нь Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын сарын 13-ний өдрийн Засгийн газрын А/448 дугаар тогтоолоор батлагдсан Эрүүл мэндийн магадлах зөвлөлийн дүрмийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдлөг болгон ажиллаж байна. “Даатгуулагч / иргэн /-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах ердийн өвчний жагсаалт, хувь хэмжээ, хугацаа”-г тогтоох Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2023 оны А/441, А/192 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан, өвчний жагсаалт даатгуулагч / иргэн /-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход ашиглаж 2024 оны гарын авлага, эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой хууль эрх зүйн	90

					баримт бичгээр мөрдөн, Эрүүл мэндийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын саналыг үндэслэн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох, сунгах болон хөдөлмөрийн нөхцөл солих зэргээр магадлан шийдвэрлэж байна. 2024 оны 2 дугаар улирлын байдлаар Эрүүл мэндийн магадлах зөвлөл нь нийт 25 удаа хуралдаж, 999 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг шийдвэрлэлээ. Үүнд: Шинээр тогтоосон-175 Сунгалт-715 Цуцалсан-109 Буцаасан-20 Эрүүл мэндийн магадлах зөвлөл нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А/60 дугаар тушаалаар Эрүүл мэндийн магадлах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн тогтоож нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Журамд заасны дагуу цахимаар хуралдаж иргэд даатгуулагч чирэгдэлгүй үйлчилж байна. Тус газар нь иргэдийн хууль эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд “Эмнэлгийн хуудас олгох, хянах журам”-ыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, уг журмыг иргэд даатгуулагч, эмнэлгийн ажилчдад сурталчлан таниулж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна. Шуурхай чанартай төрийн үйлчилгээ аяны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээ мэдээ мэдээллийг тогтмол хүргэж цахим	
--	--	--	--	--	---	--

						зөвлөгөөг 70 иргэнд хүргэж ажиллаж байна.	
Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх							
4.4.1	Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх	-	Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх	Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан.	Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна.	Тус газраас иргэд даатгуулагч, ажил олгогчийн захирал нягтлан бодогчдод нийгмийн даатгалын ажил үйлчилгээг хүртээмжтэй шуурхай хүргэх, нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт, түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг танилцуулах, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх сургалтыг тогтмол зохион байгуулж, шинээр ажил олгогчоор бүртгүүлэх заавар, гарын авлага QR код, сайн дурын даатгалд хамрагдах иргэдэд зориулсан мэдээлэл, гарын авлага QR кодыг бэлтгэн гаргасан. QR уншуулан даатгуулагчийн ажил мэргэжлийн ангилал, даатгуулагчийн төрлийн кодыг харах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Тайлан хугацаанд sicos системрээр шимтгэлийн төлөлтийн тайланг хянаж баталгаажуулсан бөгөөд тайлан авалтын хувь 95% байна. 2024 оноос эхлэн салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэнтэй холбоотойгоор ажил олгогчийг шинэ системд бүртгүүлэх мэдээллийг шинэчлэх, даатгуулагчийн мэдээлэл болон регистрийн дугаарыг үнэн зөв оруулах, даатгуулагчийн төрлийн кодыг зөв сонгож тайлагнахад анхаарч аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогчдыг тайлан шалгах цонхыг ашиглан алдаа зөрчилгүй тайлан баталгаажуулах болон холбогдох мэдээ мэдээлэл мэргэжил арга	95
			Ажил олгогчийн НДШ-ийн тайланд ирүүлэх даатгуулагчийн мэдээллийг бүрэн, зөв бүрдүүлсэн байх		- Даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн, зөв хүлээн авсан байна. - Даатгуулагчийн төрлийг бүрэн, зөв хүлээн авсан байна. - Даатгуулагчийн улсын кодыг бүрэн, зөв хүлээн авсан байна. - Даатгуулагчийн ажил мэргэжлийн ангиллыг бүрэн, зөв хүлээн авсан байна.		

						зүйн зөвлөгч өгч тайлант хугацаанд ажил олгогчийн нягтлан бодогчдод сургалт мэдээллийг тогтмол өгч зохион байгууллаа.	
4.4.2			Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх	Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан.	Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна.	2024 оны тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан тооцоо хийсэн 6616 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн өдрийн А/199 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журмын дагуу хүлээн авч, хянан цахимаар баталгаажуулан, даатгуулагчийн төрлийг давхардуулан бүртгэхгүй байх талаар нягтлан бодогч нарт заавар зөвлөгөө өгч ажилласан.	90
	Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх	-	Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх		Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна.		
			Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байх		Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байна.	Сайн дурын даатгуулагчийн мэдээлэл аймаг, дүүрэгтэй давхардсан даатгуулагч эх-23, сайн дурын даатгуулагчтай давхардсан-9 даатгуулагч эхийн бүртгэлийг залруулсан. Давхар ногдуулалт хийсэн 28 даатгуулагч, Ажил олгогчийн цалин, сайн дурын даатгуулагч эх гэрээтэй давхардсан 39 даатгуулагчийн мэдээллийг засварлаж ногдуулсан. Сайн дурын даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой 61 өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. НДЕГ-ын МТТ-өөс 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 09 тоот албан бичгээр даатгуулагчийн цалингийн мэдээллийг хөрвүүлэх тухай чиглэлийг ирүүлсэн бөгөөд тайлант хугацаанд өргөдлийн дагуу 55 даатгуулагчийн мэдээллийг засах, регистрийн дугаарыг нэгтгэж мэдээллийг баазыг шинэчлэсэн.	

					2024 он 2 дугаар улиралд сайн дураар даатгуулах тухай гэрээ байгуулсан боловч хуулийн хугацаандаа шимтгэлээ төлөөгүй хугацаа хожимдуулан төлсөн 170 даатгуулагчид нийт 5.5 сая төгрөгийн алданги ногдуулж алдангийн нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн. Программд 2 бүртгэл үүссэн 53 даатгуулагч мэдээллийг залруулан ногдуулалт хийж ажилласан. Сайн дурын даатгуулагчийн мэдээлэл аймаг, дүүрэгтэй давхардсан даатгуулагч эх-23, сайн дурын даатгуулагчтай давхардсан-9 даатгуулагч эхийн бүртгэлийг залруулсан. Давхар ногдуулалт хийсэн 28 даатгуулагч, Ажил олгогчийн цалин, сайн дурын даатгуулагч эх гэрээтэй давхардсан 39 даатгуулагчийн мэдээллийг засварлаж ногдуулсан. Сайн дурын даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой 61 өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.	
					Байгууллагын дотоод сүлжээний ажиллагаа, ашиглалтыг хангаж, нийт 12 байцаагчийн компьютерын үйлдлийн системийг шинээр суулгасан. Нийгмийн даатгалын үйлчилгээнд өдөр тутам ашиглагддаг программ хангамжийг компьютерт суулгаж, нэмэлт шинэчлэлтүүдийг тухай бүрт нь суулгаж шинэчлэн ажилласан. МТТ-өөс гаргасан журмын дагуу 20 байцаагчийн өдөр тутамд ашигладаг программуудын нууцлалыг АДМИН программын удирдлагаар хэрэглэгчдийн нууц үгийг солиулж, программын аюулгүй ажиллагааны талаарх зөвлөгөө мэдээлэл өгч, улирал тутам нууц үгийг өөрчлүүлж гарын үсгээр баталгаажуулсан.	
	Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах	-	Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх	-	Програм хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, байцаагч ажилтнууд програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна. МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна.	95

4.4.3						Мэдээлэл технологийн төвтэй холбогдож Байгууллагын албаны мэйл хаягийг 6 байцаагч ажилтанд шинээр авч, 20 байцаагч ажилтны нууц үгийг солиулсан. Дотоод хяналтын программыг 3 байцаагчид, дотоод чат буюу инбитын эрхийг 5-г шинээр нээлгэж, ашигладаггүй 3 инбит хаягийг устган зохицуулалтыг хийж ажилласан. “Нийгмийн халамж, хөдөлмөр, нийгмийн даатгалын газруудад вебд суурилсан дотоод хяналт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны систем” хөгжүүлэх ажлын хүрээнд ndaatgal.chd.gov.mn веб системийг нэвтрүүлж дугаар, үнэлгээний системийн дотоод хяналт, албан хаагчдын үнэлгээ харах, иргэд даатгуулагчдын өгсөн материал хаана ямар шатан дээр явааг харах, албан хаагчдын өөрийгөө сорих сорилт бөглөх бүхий цогц веб системийг ашиглаж нэмэлт өөрчлөлт, шинэчлэлтийг хийж ажиллаж байна.	

---oOo---